

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2020 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ



Эд хогшил, бараа материал худалдан авах болон урсгал засварын зардлыг орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган, хэрэгжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна.

Сүхбаатар сум
2020 он 06 дугаар сар

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа</p> <p>Аудитын менежер Б.Батмөнх</p> <p>Ахлах аудитор Ц.Отгонбаяр</p> <p>Аудитор Ж.Цогт</p> <p>2020 он</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70363036 дугаарын утас, Selenge@audit.gov.mn цахим сайтаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд</p>	<p>Товчилсон үгийн жагсаалт</p> <p>Аудитын хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд,</p> <p>1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу?</p> <p>1.1 Аймаг, сумд нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нээгдсэн бодлого боловсруулаагүй, төсөл, арга хэмжээг үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.</p> <p>1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад зураг, төсөв нь хийгдээгүй болон урсгал зардлын шинж чанартай төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлж байна.</p> <p>2. Орон төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?</p> <p>2.1 Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг холбогдох стандарт, норм, дүрэм, журмын дагуу боловсруулаагүй байна.</p> <p>2.2 Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 93,6 хувийг бүрэн хэрэгжүүлсэн байна.</p> <p>2.3 Тус бүр 1 төсөл арга хэмжээнд захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.</p> <p>2.4 Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөөгүй, бодит үр нөлөөг тооцоогүй байна.</p> <p>Илрүүлсэн зөрчил</p> <p>Дүгнэлт</p> <p>Зөвлөмж</p> <p>Хавсралт 1-6</p>
--	---

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БСУГ	Боловсрол, соёл, урлагийн газар
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЭА	Сэлэнгэ аймаг
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ХО	Хөрөнгө оруулалт
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХА	Харьцуулалтын арга
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудиторт 2020 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүнг албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- **Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй байна уу?**
- **Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?**

Хамрах хүрээ:

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлсэн хөрөнгө, оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийг аймаг болон сумын ЗДТГ, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, аймгийн ОНӨГ, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтнууд, худалдан авах ажиллагааны баримт, материалуудыг хамруулан шалгав.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан, аймаг, сумдын ЗДТГ, аймгийн Орон нутгийн өмчийн газар, “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны санхүүгийн тайлан, мэдээ, шаардлагатай бусад баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад Барилгын тухай хууль, Төсвийн тухай хууль, ТБОНӨХБАУХА тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан “*Барилгын ажлын захиалагчийн дүрэм*”, 2018 оны 97 дугаар тогтоолоор батлагдсан “*Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм*”, 317 дугаар тогтоолоор батлагдсан “*Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм*”, Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар СЭА-2020/02-ГА

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”, 84 дүгээр тушаалаар баталсан “Цахим хуудаст худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг зарлан мэдээлэх журам”, 2014 оны 212 дугаар тушаалаар баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”, 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”, 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам” болон бусад холбогдох УИХ, Засгийн газрын тогтоол, хууль, эрхийн актуудыг шалгуур болгон ашиглав.

Үндсэн мэдээлэл:

Сэлэнгэ аймагт 2019 онд орон төсвийн хөрөнгө оруулалтаар 785.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгөөр 549.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ, сумдын ИТХ-аар 885.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээ зэрэг нийт 2,220.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. /Хавсралт 1,2-т дэлгэрэнгүй харуулав. /

Аймгийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр хэрэгжсэн 936.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээнээс 670.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 245.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 20.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна.

Сумдын хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр хэрэгжсэн 566.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээнээс 258.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 120.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 95.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг зөвлөх үйлчилгээний, 91.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэжээ. /Хавсралт 3,4-т дэлгэрэнгүй харуулав. /

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 50 төсөл, арга хэмжээнээс, санхүүжилт бүрдээгүйн улмаас 3 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулагдаагүй, он дамжин хэрэгжих 8 төсөл, арга хэмжээ, тайлант онд худалдан авах ажиллагаа нь зарлагдаж, шинээр эхэлсэн 39 төсөл, арга хэмжээнд 1,491.1 сая төгрөгийн гэрээ байгуулагдсан байна. /Хавсралт 5-т дэлгэрэнгүй харуулав. /

Гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээнээс 44 нь гэрээт хугацаандаа бүрэн хэрэгжсэн бол 3 төсөл, арга хэмжээ нь он дамжсан байна.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын СЭА-2020/02-ГА

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, аудитор Ж.Цогт нар 2020 оны 4 дүгээр сарын 27-оос 06 дугаар сарын 19-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

1.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулж, түүний хүрээнд төсөл, арга хэмжээг төлөвлөж, батлуулсан уу?

Аймаг, сумд нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулаагүй, төсөл, арга хэмжээг үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.

1.1.1 Аймгийн ИТХ-ын 2019 оны 10 дугаар сарын 69 дүгээр тогтоолоор 785.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээ, замын сангийн хөрөнгөөр 549.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээ, сумдын ИТХ-аар 885.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээ зэрэг нийт 2,220.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 50 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 1 / сая төгрөг/

№	Орон нутгийн хөрөнгө оруулалт эх үүсвэрээр	Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолын		Батлагдсан төсөл, арга хэмжээ	
		Огноо	Дугаар	Тоо	Төсөвт өртөг
1	Аймгийн хөрөнгө оруулалт	2019.10.04	69	13	785.8
2	Замын сангийн хөрөнгө оруулалт	2019.10.04	69	3	549.0
Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар:					
3	Алтанбулаг	2018.12.10	56	1	35.0
4	Баруунбүрэн	2018.12.19	39	2	13.9
5	Баянгол	2018.12.14	68	3	75.0
6	Ерөө	2018.12.14	50	7	127.7
7	Мандал	2018.12.19	125	3	246.7
8	Орхон	2018.12.19	39	5	25.0
9	Сайхан	2018.12.14	55	6	152.9
10	Сүхбаатар	2018.12.11	102	7	209.7
Дүн				34	885.9
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн				50	2,220.7

График-1



1.1.2 Графикаас харахад нийт батлагдсан төсөл, арга хэмжээний 28 хувь буюу 14 төсөл, арга хэмжээ нь барилга, байгууламж барих, 30 хувь буюу 15 төсөл, арга хэмжээ нь их засварын ажил, 32 хувь буюу 16 төсөл, арга хэмжээ нь тоног,

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

төхөөрөмж нийлүүлэх, 8 хувь буюу 4 төсөл, арга хэмжээ нь зураг төсөв зохиох төсөл, арга хэмжээ байна.

1.1.3 Аймгийн ИТХ-ын 2018 оны 51 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар 2019 оны аймгийн болон замын сангийн хөрөнгө оруулалтад анх 1,324.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд төсвийн жилийн дундуур 2 удаа нэмж тодотгол хийж, 2019 оны 69 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар 1,334.8 сая төгрөгийн өртөгтэй 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр эцэслэн баталсан байна. */Хавсралт 1-д дэлгэрэнгүйгээр харуулав./*

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр батлагдсан төсөл арга хэмжээний анхны болон эцсийн төлөвлөгөөг харьцуулан харуулбал:

Хүснэгт 2 / сая төгрөг/

№	ТАХ-ний зориулалт	2018.12.05-ны өдрийн 51 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт		2019.10.04-ний өдрийн 69 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт	
		тоо	дүн	тоо	дүн
Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт		11	775.0	13	785.8
1	Урьд оноос шилжиж ирсэн ХО	1	398.6	1	398.6
2	Барилга, байгууламж	2	170.0	2	170.0
3	Их засвар	2	40.0	3	45.8
4	Тоног, төхөөрөмж	6	166.4	7	171.4
Замын сангийн ХО		3	549.0	3	549.0
Нийт дүн		14	1,324.0	16	1,334.8

1.1.4 Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.6-д “*ТЕЗ, аймаг, нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, ... харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна*” гэж заасан байдаг.

1.1.5 Гэтэл аймаг, сумд нь төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, дунд болон урт хугацааны төлөвлөгөөгүй боловсруулаагүй бөгөөд төсөл, арга хэмжээг тэргүүлэх чиглэл, ач холбогдлоор нь эрэмбэлэлгүйгээр Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, 2019 оны үндсэн чиглэлийг үндэслэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.

1.1.6 “Аймгийн эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хөрөнгө оруулалт, дэд бүтэц зэрэг салбаруудын бодлого шинэчлэлийн хүрээнд 249 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 16 төсөл, арга хэмжээг аймаг болон замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

1.1.7 Алтанбулаг, Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Мандал, Орхон, Сайхан, Сүхбаатар зэрэг 8 сум 885.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээг сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан байна. /Хавсралт 2-т дэлгэрэнгүйгээр харуулав. /

1.1.8 Алтанбулаг сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 56 дугаар тогтоолоор 2019 оны хөрөнгө оруулалтад төсөл, арга хэмжээний нэр, хэрэгжих хугацаа, байршил нь тодорхой бус 35.0 сая төгрөгийн төсөв баталж, 2019 оны 11 дугаар сарын 13-ны өдрийн 86 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийж уг төсөл, арга хэмжээг хассан байна.

1.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ТЭЗҮ, зураг, төсөв нь иж бүрэн хийгдсэн болон хуулийн шаардлага хангасан төсөл, арга хэмжээг тусгаж байгаа эсэх?

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад зураг, төсөв нь хийгдээгүй болон урсгал зардлын шинж чанартай төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлж байна.

1.2.1 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 3.2-т “тухайн санхүүгийн жилд эхлүүлэхээр төлөвлөж буй барилга байгууламж нь инженер хайгуулын судалгааг хийж, дүгнэлт гаргасан, зураг төслийг экспертизээр батлуулсан, барилга барих газар болон инженерийн шугам, сүлжээний асуудлыг бүрэн шийдсэн, үр ашигтай ТЭЗҮ, тооцоогоор нотлогдсон зэрэг барилгын ажлыг эхлүүлэх нөхцөлийг хангасан, урсгал зардлын урьдчилсан тооцоо хийгдсэн байна” гэж тус тус заасан байдаг.

1.2.2 2019 онд аймаг, сумын хөрөнгө оруулалт, замын сангийн эх үүсвэрээр шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан ТЭЗҮ хийх зөвлөх үйлчилгээний 4 төсөл, арга хэмжээнээс бусад 46 төсөл, арга хэмжээнээс 28 төсөл, арга хэмжээний зураг төсөв тооцоо судалгааг батлахаас өмнө хийсэн бол 687.5 сая төгрөгийн өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээний / Хүснэгт 3/ зураг, төсөв, тооцоо судалгааг төлөвлөсний дараа хийж, 192.0 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг / Хүснэгт 4/ зураг, төсөв тооцоо судалгаагүйгээр хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 /сая төгрөг/

Баталсны дараа зураг, төсөв, тооцоо судалгааг хийсэн төсөл, арга хэмжээ

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зураг, төсөв хийсэн компани, гэрээний огноо
Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар			
1	Аймгийн цагдаагийн газарт хяналтын пост барих	60.0	Талхун арал ХХК, 2019.06.14

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

2	Түшиг сумын ЗДТГ-ын гадна фасад засвар	10.0	Талхун арал ХХК, 2019.05.13
3	БСУГ-ын барилгын засвар	30.0	Талхун арал ХХК, 2019.03.17
4	БСУГ-ын барилгын нэмэлт засвар	5.8	Талхун арал ХХК, 2019.10.11
Дүн		105.8	
Замын сангийн хөрөнгө оруулалтаар			
5	Сүхбаатар суманд авто зам барих	300.0	Эм Эн Эс Жи ХХК, 2019.05.10
6	Хушаат сумын төвөөс Орхон голын гүүр хүртэл хайрган хучилттай зам барих	200.0	Эм Эн Эс Жи ХХК, 2019.05.10
Дүн		500.0	
Сумдын хөрөнгө оруулалтаар			
7	Бугант гудамжны гэрэлтүүлэг / Ерөө сум /	21.9	Бурхант орд ХХК, 2019.02.15
8	Бугант тосгонд гэрэлт гудамж хийх /Ерөө сум/	20.0	Бүрэг Энержи ХХК, 2019.04.03
9	Бугант тосгонд явган хүний зам тавих /Ерөө сум/	10.0	Мэргэшсэн төсөвчин Д.Солонго,
10	24-р цэцэрлэгийн сантехникийн засвар /Сайхан сум/	19.9	Бурхант орд ХХК, 2019.01.11
11	55 гэрлийн толгой солих /Сүхбаатар сум/	9.9	Мэргэшсэн төсөвчин 3.Энхжаргал, 2019.02.19
Дүн		81.7	
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн		687.5	

Хүснэгт 4 /сая төгрөг/

Зураг, төсөвгүйгээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг
Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар		
1	Сайхан суманд төрийн албан хаагчийн 10 айлын байр барих	110.0
2	Сүхбаатар сумын дотор зам засвар	49.0
3	Аймгийн ИТХ-д хүндэт тэмдэг худалдан авах	5.0
Дүн		164.0
Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар		
4	Зоорь засах / Баруунбүрэн сум/	8.0
5	Сумын угтах, үдэх хаалганы гадна тохижилт /Орхон сум/	10.0
6	Хэсгүүдийн гудамж, талбайн, тохижилт /Орхон сум/	5.0
7	Сумын зочид буудлын тохижилт /Орхон сум/	5.0
Дүн		28.0
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн		192.0

1.2.3 Төсөл, арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийдэггүйгээс аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр БСУГ-ын барилгын ажилд анх баталсан 30.0 сая төгрөг нь хүрэлцэхгүйд хүрч нэмэлт засвар нэрээр дахин 5.8 сая төгрөг баталсан, өөрөөр хэлбэл 1 төсөл арга хэмжээг 2 төсөл, арга хэмжээ болгон баталсан байна.

Мөн Сайхан суманд төрийн албан хаагчийн 10 айлын орон сууц барих 110.0 сая төгрөгийн эх үүсвэр нь хүрэлцэхгүйд хүрч төсөл, арга хэмжээний нэршлийг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

аймгийн ИТХ-ын 2019 оны 62 дугаар тогтоолоор “Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах” болгон өөрчилсөн байна.

1.2.4 Хүснэгт 3-аас харахад 19.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний зураг төсвийг тусгай зөвшөөрөл бүхий зураг, төсвийн компанид харьяалагддаггүй, зөвхөн төсөвчний тамга, тэмдэгтэй Д.Солонго, З.Энхжаргал зэрэг иргэдээр 0.8 сая төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байгаа нь Барилгын тухай хуулийн 14.1¹, 17.1² дэх заалтуудыг зөрчсөн байна.

1.2.5 Ерөө сум нь 39.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Ерөө сумын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийн зураг төсөв хийх” зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг тооцоо судалгаагүй /1800 кв цаг цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангахаар / хийснээс гүйцэтгэгчээр шалгарсан “Алтайн газрын хүч” ХХК – тай байгуулсан гэрээг цуцалсан буюу уг төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

1.2.6 Өмнөх онд хийгдсэн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинж чанартай, тухайн байгууллагын урсгал зардалд тусгах боломжтой эд хогшил, бараа материал худалдан авах, урсгал засварын зардал зэрэг 15.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээг аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд, 72.3 сая төгрөгийн өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээг сумдын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 5 /сая төгрөг/

Хөрөнгө оруулалтын төсөвт тусгаж хэрэгжүүлсэн урсгал зардлууд

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Төсөвт өртөг
Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:		
1	Аймгийн ИТХ-д хүндэт тэмдэг худалдан авах	5.0
2	Түшиг сумын ЗДТГ-ын гадна фасад засвар	10.0
Дүн		15.0
Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар		
3	Зоорь засах /Баруунбүрэн сум/	8.0
4	Гүний худгийн шугам засварлах /Баруунбүрэн сум/	5.9
5	Иргэний танхимын зураг төсөв хийлгэх /Баянгол сум/	13.0
6	Геологийн дүгнэлт гаргах. Иргэний танхим /Баянгол сум/	2.0
7	Сумын угтах, үдэх хаалганы гадна тохижилт /Орхон сум/	10.0
8	Хэсгүүдийн гудамж, талбайн тохижилт /Орхон сум/	5.0
9	Цагдаагийн хэсэгт дрон авах /Орхон сум/	3.0
10	Сумын ЗДТГ-т камер /аппарат/ худалдан авах /Орхон сум/	2.0
11	Сумын зочид буудлын тохижилт /ор, ширээ, сандал/ /Орхон сум/	5.0
12	55 гэрлийн толгой солих /Сүхбаатар сум/	9.9
13	Эмнэлгийн эмчилгээний тасгийн засвар /Сүхбаатар сум/	8.5
Дүн		72.3
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт дүн		87.3

¹ Барилга байгууламжийн зураг төсөл, барилгын ажил, материал үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

² Зураг төсөл зохиогч нь Иргэний хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй: 17.1.1. тусгай зөвшөөрлийн үндсэн дээр зураг төсөл боловсруулах ажил, үйлчилгээ эрхлэх.

1.2.7 Нөгөө талаас орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга угсралт, их засвар зэрэг бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнүүдийг бус урсгал засвар, тоног төхөөрөмж, машин, техник худалдан авах зэрэг цаг үеийн шаардлагатай жижиглэсэн төсөл, арга хэмжээг тусгаж баталсан нь хөрөнгө оруулалтын мөн чанар, үр өгөөжийг бууруулж байна. Тухайлбал аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан нийт 13 төсөл арга хэмжээний 4 нь авто машин худалдан авах, 3 нь тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах, 3 нь урсгал засварын зардал байгаа бөгөөд үлдсэн 3 буюу дөнгөж 23,1 хувь нь барилга угсралтын ажил буюу орон сууц худалдан авах төсөл, арга хэмжээ байна.

1.2.8 Төсвийн тухай хуулийн 6.6.6 дахь “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалтыг зөрчин аймаг, сумдын хөрөнгө оруулалтаар улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардалд нийт **192.3** сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн байна. Үүнд:

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:

- Аймгийн Цагдаагийн газарт хяналтын пост барихад 60.0 сая төгрөг,
- Аймгийн Цагдаагийн газарт хурд хэмжигч болон согтуурлын хэмжээ тогтоогч авахад 60.0 сая төгрөг,
- Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын засварын ажилд 35.8 сая төгрөг,

Сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар:

- **Орхон сум:** Цагдаагийн хэсэгт дрон худалдан авахад 3.0 сая төгрөг,
- **Сайхан сум:** Сум дундын эмнэлгийн уламжлалтын тасагт тоног төхөөрөмж авахад 10.0 сая төгрөг, Сумын цагдаагийн хэлтэст хурд хэмжигч авахад 15.0 сая төгрөг,
- **Сүхбаатар сум:** Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмчилгээний тасгийн засварт 8.5 сая төгрөг гэх мэт,

1.2.9 ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8.4-д “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”, 8.7.1-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэж заасан байдаг.

1.2.10 Дээрх зохицуулалтын дагуу төсөл, арга хэмжээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь багцалж тендер шалгаруулалт явуулахаар аймгийн ИТХ-аар батлуулах ёстой атал нээлттэй болон харьцуулалтын аргаар тендер шалгаруулахаас зайлсхийх зорилгоор аймгийн хөрөнгө оруулалтаар авто машин худалдан авах гэсэн 1 чиглэлийн төсөл арга хэмжээг / 70.0 сая төгрөгийн өртөгтэй / 4 төсөл арга хэмжээ, болгон хувааж батлуулсан байна. Үүнд:

- Алтанбулаг сумын ИТХ-д автомашин авах 15.0 сая төгрөг,
- Шаамар сумын ИТХ-д автомашин авах 15.0 сая төгрөг,

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

- Жавхлант сумын ЗДТГ-т автомашин авах 25.0 сая төгрөг,
- Орон нутгийн өмчийн газарт автомашин авах 15.0 сая төгрөг,

2.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулагдсан уу?

Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг холбогдох стандарт, норм, дүрэм, журмын дагуу боловсруулаагүй байна.

2.1.1 Аймгийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр хэрэгжсэн 936.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээнээс 670.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 245.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 20.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн байна. */Хавсралт 3-т дэлгэрэнгүйгээр харуулав./*

2.1.2 Аймгийн Засаг даргын 2019 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/33 дугаар захирамжаар тус бүр 15.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Алтанбулаг, Шаамар сумын ИТХ-д автомашин авах 2 төсөл, арга хэмжээний эрхийг сумдын ЗДТГ-т шилжүүлж, гүйцэтгүүлсэн байна.

2.1.3 Сумдын хөрөнгө оруулалтаар 2019 онд шинээр хэрэгжсэн 566.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээнээс 258.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг НТШ-ын аргаар, 120.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж, 95.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг зөвлөх үйлчилгээний, 91.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг шууд худалдан авах аргаар гүйцэтгэжээ. */Хавсралт 4-д дэлгэрэнгүйгээр харуулав./*

2.1.4 Аймгийн хөрөнгө оруулалтаар болон замын сангийн хөрөнгөөр худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулах 4 төсөл, арга хэмжээний “Үнэлгээний хороо”-г аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар тус бүр 5-7 хүний бүрэлдэхүүнтэй, харьцуулалтын аргаар зохион байгуулах 8 төсөл, арга хэмжээний ажлын хэсгийг аймгийн ОНӨГ-ын даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

2.1.5 Баянгол, Ерөө сумдууд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Ажлын хэсэг”-ийг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй, ялангуяа бүх ажлын хэсэгт дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг явцуу хүрээнд давхардуулан томилон ажиллуулж байгаа нь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг дагуулж байна.

Иймд дээрх сумдын ЗДТГ-ын дарга нь тендер сонгон шалгаруулах ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийг байнга сэлгэн, томилох шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

2.1.6 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх шууд худалдан авахаас бусад 24 төсөл, арга хэмжээний тендерийн баримт, бичгийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан тендерийн жишиг баримт, бичгийн дагуу боловсруулсан байна.

2.1.7 Гэвч тендерийн баримт, бичгийн чухал бүрдэл хэсэг болох техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа ТБОНӨХБАҮХ тухай хуулийн 11.1-д “Захиалагч техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ дараах шаардлагыг хангасан байна”: 11.1.2-д “үндэсний стандарт, техникийн шаардлага, норм, норматив, дүрэм, зааварт үндэслэх, үндэсний стандарт, техникийн норм байхгүй тохиолдолд Монгол Улсын хүлээн зөвшөөрсөн олон улсын стандартад үндэслэх;” гэсэн заалтыг мөрдөөгүй дараах төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- *Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах” ажлын техникийн тодорхойлолтод ашиглалтад орсон болон цаашид ашиглах боломжит хугацаа, засвар үйлчилгээ хийгдсэн эсэх, эзэмшил нь тодорхой байх, хөрөнгийн үнэлгээ, зах зээлийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлуулсан байх, чанарын баталгаа хийгдсэн байх зэрэг нийтийн эзэмшлийн орон сууцанд тавигдах шаардлагуудыг огт тусгаагүй байна.*

2.1.8 Дээрх төсөл, арга хэмжээний тендерт 2 оролцогч материал ирүүлсэн бөгөөд техникийн тодорхойлолтыг үндэслэлгүй боловсруулснаас тендерийн материал бүрдүүлэлт, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад дараах зөрчил гарчээ. Үүнд:

- *Тендерт оролцогч Жавхлант оргил ХХК нь иргэн Б.Санжаахандын эзэмшилд бүртгэгдсэн, итгэмжлэл олгоогүй 7 өрөө байрыг санал болгосон материал ирүүлсэн байна.*
- *Тендерт оролцож, гүйцэтгэгчээр шалгарсан Сүж ундарга ХХК нь Сайхан сумын иргэн Ж.Нармандахын эзэмшилд бүртгэлтэй, 2019 оны 11 дүгээр сарын 22-нд 6 сарын хугацаатай итгэмжлэл олгосон орон сууцыг худалдан борлуулах санал ирүүлсэн байна. Бид аудитын явцад буюу итгэмжлэлийн хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө эзэмшлийг тулган баталгаажуулахад уг орон сууцыг Сайхан сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд тусгасан боловч эзэмшлийг шилжүүлээгүй байлаа. Энэ нь төсвийн хөрөнгө үрэгдэн шамшигдах эрсдэлийг үүсгэж байна.*

2.1.9 Шууд худалдан авах 66.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээнээс бусад 2019 оны бүх худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд оруулсан байна.

2.1.10 Баруунбүрэн, Ерөө сумд шууд худалдан авах төсөл арга хэмжээг ч цахимаар зохион байгуулсан нь тендерт оролцогчдын эрх тэгш, шударга байх болон хамгийн бага үнийн зарчмыг хангасан давуу талтай болсон байна. Тухайлбал, Ерөө сумаас цахимаар зарласан 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгоны иргэний танхим, тоног төхөөрөмж худалдан авах” ажлын тендерт 5 оролцогч материал ирүүлснээс шаардлага бүрэн хангаж, хамгийн бага буюу 7.5 сая төгрөгийн үнийн санал ирүүлсэн Мед буян ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

2.1.11 Тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө, тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.10³, 3.1⁴-д заасны дагуу аймгийн Орон нутгийн өмчийн газар хянаж, нэгтгэхээр зохицуулсан атал тус байгууллагын нэгтгэсэн тайланд дараах зөрчлүүд оршиж байна. Үүнд:

- Аймгийн төсвөөс санхүүжсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тайланд 10.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг дутуу,
- Баруунбүрэн сумын шууд худалдан авах 5.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг дутуу,
- Жавхлант, Шаамар сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 73.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг сумын хөрөнгө оруулалтаар тайлагнасан байна.

2.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулсан уу?

Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 93.6 хувийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.2.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, замын сангийн хөрөнгөөр 2019 онд 50 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан боловч санхүүжилт бүрдээгүйн улмаас 3 төсөл, арга хэмжээнд гэрээ байгуулаагүй бөгөөд он дамжин хэрэгжих 8, тайлант онд шинээр эхэлсэн 39 төсөл, арга хэмжээнд 1,491.1 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна. /Хавсралт 5-д дэлгэрэнгүйгээр харуулав./

2.2.2 Он дамжин хэрэгжих аймгийн хөрөнгө оруулалтын 1, Сүхбаатар сумын 5, Мандал сумын 2 буюу нийт 452.7 сая төгрөгийн өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээнд 2019 онд гэрээт ажлын үлдэгдэл санхүүжилт 352.4 сая төгрөгийг олгох төсөв баталсан байна.

2.2.3 Ингэснээр 2019 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн 47 төсөл, арга хэмжээний 44 нь гэрээт хугацаанд бүрэн хэрэгжсэн бол худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон, хугацаа алдсан зэргээс дараах 3 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Замын сангийн 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сүхбаатар суманд авто зам барих ажлын худалдан авах ажиллагаа 3 удаа амжилтгүй болсноос хугацаа алдан, гэрээг 9 сард байгуулсан боловч захиалагч гүйцэтгэх ажлын тоо, хэмжээнд өөрчлөлт оруулснаас 10 сард ажил эхэлсэн, тайлант оны гүйцэтгэл 40 хувьтай,
- Баянгол сумын 13.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Иргэний танхимын зураг төсөв хийлгэх” зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагаа 3 удаа амжилтгүй болсноос 12-р сард гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, 2020 он 1-р сард хүлээлгэн өгөхөөр гэрээг байгуулсан, тайлант оны гүйцэтгэл 50 хувьтай,

³ Захиалагчийн боловсруулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан аргачлал, шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулна.

⁴ Төсвийн ерөнхийлөн захирагч ... нь тухайн онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг журамд заасан маягтуудын дагуу нэгтгэж бичгээр болон файлаар төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ... ирүүлнэ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

- Сайхан сумын 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайхан сумын хот төлөвлөлтийн ТЭЗҮ хийлгэх” зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил нь 2 үе шаттай явагдаж, 12-р сард гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, 2020 он 5-р сард хүлээлгэн өгөхөөр гэрээг байгуулсан, тайлант оны гүйцэтгэл 46 хувьтай.

2.2.4 Аймгийн ЗДТГ-ын СТСХ болон сумдын ЗДТГ-ын Санхүүгийн алба нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 4.5-д заасны дагуу төсөл, арга хэмжээ бүрээр захиалагчийн хянаж, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, санхүүжилт хүссэн материалыг хянаж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийг олгосон байна.

2.2.5 Аймгийн ЗДТГ нь аймгийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний эцсийн санхүүжилтийг улсын комиссын акт, гэрээ дүгнэсэн акт, гэрээний биелэлтийг үндэслэн олгож байгаа бөгөөд гэрээт хугацааг хэтрүүлсэн 1 гүйцэтгэгчид 0.6 сая төгрөгийн алданги тооцож, хэрэгжиж дууссан 3 төсөл, арга хэмжээнд төсөвт өртгийн 5 хувиар буюу 17.6 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг төвлөрүүлсэн байна.

2.2.6 Сумдын ЗДТГ-ын Санхүүгийн алба нь сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний сүүлийн санхүүжилтийг олгоходоо ажлын гүйцэтгэл, улсын комиссын актыг үндэслэж байгаа боловч гэрээний биелэлт, үр дүнг гэрээ дүгнэсэн актаар үнэлээгүй байна.

2.2.7 Ерөө сум нь 67.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний хяналтын төсөвт 1.2 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг тооцсон боловч захиалагч гүйцэтгэгчийн хамтарсан актгүй, гэрээнд тусгалгүйгээр магадалшгүй ажлын зардлыг гүйцэтгэгчид олгосон байна.

2.2.8 ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дахь “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно.” гэж заасан боловч Мандал сум нь 198.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын гадна фасад, дээвэр засварын ажил”-ын гэрээнд төсөвт өртгийн 5 хувь буюу 9.9 сая төгрөгийн чанарын баталгааг тусгаагүй байна.

2.3 Гэрээний хэрэгжилтэд үр нөлөө бүхий хяналтыг хэрэгжүүлсэн үү ?

Тус бүр 1 төсөл арга хэмжээнд захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

2.3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлсэн 39 төсөл, арга хэмжээнээс тоног төхөөрөмж худалдан авах 16 болон бага төсөвт өртөгтэй, урсгал засварын шинж чанарт 6 төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналтыг аймаг, сумдын ЗДТГ хэрэгжүүлж, бусад 17 төсөл, арга хэмжээний явцын

болон техникийн хяналтыг “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ хэрэгжүүлсэн байна.

2.3.2 Захиалагч болох аймаг, сумдын ЗДТГ нь Барилгын тухай хуулийн 37.1.4⁵, 37.2⁶ -д заасны дагуу “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-тай барилгын ажлын захиалагчийн хяналтыг гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан байна.

2.3.3 Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийн 3.9-д “Захиалагч үе шатны ажилд техникийн хяналт тавих, гүйцэтгэлийн тэмдэглэл, ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулга хийсэн акт, санхүүжилтийн тооцоо, холбогдох бусад баримт бичгийг барилгын ажил гүйцэтгэх график, гэрээний дагуу барилгын үйл ажиллагаанд оролцогчтой хамтран хянаж, баталгаажуулахаас гадна техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдтэй хамтарсан үзлэг шалгалтыг урьдчилан сэргийлэх зорилгоор тухай бүр хийсэн байна.” гэж заасан байна.

2.3.4 Дээрх заалтын дагуу “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ нь төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулж, барилгын ажлын үе шат бүрд захиалагчийн хяналтыг зохих дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж, гарсан зөрчлийг арилгуулах, баримт, бичгийн бүрдлийг хангуулах, ашиглалтад хүлээн авах, барилга байгууламж, засварын ажлыг гэрээт хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх чиглэлээр ажилласан байна.

2.3.5 Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилга захиалагчийн дүрэм”-ийг баримталж, барилга угсралтын ажилд хяналтыг хэрэгжүүлэн, ил, далд ажлыг актаар баталгаажуулан, барилгыг ашиглалтад хүлээлгэн өгөх үед захиалагчийн техникийн хяналт хийсэн нэгдсэн дүгнэлт өгч баталгаажуулсан байна.

2.3.6 Харин Ерөө сумын 15.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгонд гүний худаг гаргах /барилгатай/”-ажлын захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллага болох “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлэлгүй, 0.3 сая төгрөгийн хяналтын зардлыг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

2.3.7 Төсөл, арга хэмжээний зураг төсөв зохиогч нь БХБС-ын 2016 оны 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1⁷-д заасны дагуу төсөл, арга хэмжээ тус бүр дээр захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэн, нэгдсэн дүгнэлтийг захиалагчид хүлээлгэн өгсөн байна.

2.3.8 Харин аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 49.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар сумын дотор зам засвар”-ын ажилд зураг төсөв

⁵ барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах;”

⁶ Захиалагч барилгын үйл ажиллагаанд оролцох өөрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, мэргэжлийн хуулийн этгээдээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

⁷ Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

зохиогчийн хяналтын гэрээ байгуулаагүй, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

2.3.9 Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ... хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.” гэж заасан байдаг.

2.3.10 Гэвч аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлэгч аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2019 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт шалгалт хийгээгүй байна.

2.4 Орон төсвийн хөрөнгө оруулалт тухайн жилд хүрэх зорилтот түвшинг хангаж, түүний үр ашгийг тооцож байна уу?

Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөөгүй, бодит үр нөлөөг тооцоогүй байна.

2.4.1 Аймаг болон сумдын ЗДТГ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 3.6⁸-д заасны дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтад тусгуулах төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэж, тооцоо, судалгаа, дүгнэлт хийж, арга хэмжээ тус бүрээр бодит үр нөлөөг тооцохоор зохицуулагдсан атал хэрэгжүүлээгүй байна.

2.4.2 Уг журмын 4.22-т “Хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй” гэж заасан байдаг.

2.4.3 Гэтэл Ерөө сумын ЗДТГ нь зураг, төсөвт тусгагдаагүй ажилд буюу зайлшгүй хийх шаардлагатай нэмэлт ажил гарсан гэх шалтгаанаар захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч талуудын хамтарсан шийдвэрээр “Бугант гудамжны гэрэлтүүлэг”-ийн ажилд тендерийн хэмнэлтээс 2.9 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байна. Энэ нь тендер шалгаруулалтын үр дүнг бууруулж, сонгон шалгаруулалтаар шалгарсан төсөвт өртгийг нэмэгдүүлж байна.

2.4.4 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн 47 төсөл, арга хэмжээний 44 төсөл, арга хэмжээг комиссын актаар хүлээн авч, бүрэн ашиглаж байгаа буюу 93.7 хувь нь зорилтот түвшинг хангасан байна.

⁸ “ТЭЗ, аймаг, нийслэлийн тухайн санхүүгийн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь тухайн захиалагчийн дунд хугацаанд хэрэгжүүлэх төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй харилцан уялдсан байхын зэрэгцээ салбарын гол тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалтын ач холбогдол, тухайн төслийн хэрэгжилттэй уялдуулан эрэмбэлсэн байна”,

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

2.4.5 Төлөвлөсөн болон гэрээт хугацаанд ашиглалтад хүлээлгэн өгөөгүй, бүрэн хэрэгжээгүй 3 төсөл арга хэмжээ, түүний шалтгааны талаар тайлангийн **Б.2** дугаар хэсэгт тодорхой дурдсан болно.

2.4.6 2019 онд ашиглалтад орсон төсөл арга хэмжээг бүртгэл, тайланд үнэн зөв тусгасан байна.

2.4.7 Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онд хийгдсэн аудитаар 9 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмж дутуу хэрэгжилттэй, 3 зөвлөмж огт хэрэгжээгүй байна. Үүнд:

- Мандал сумын нэгдсэн эмнэлэгт суурилагдсан компьютерт томографын аппарат нь ашиглалтад орсон боловч өвчнийг нарийн оношилж чадахгүй, өнөөгийн эмчилгээний шаардлагыг хангахгүй байгаагаас цаашид эмчилгээнд ашиглах боломжгүй байна.
- Аймгийн Нэгдсэн эмнэлэгт суурилагдсан компьютерт томографын аппаратыг гүйцэтгэгч “Гал инженеринг сервис” компани нь бүрэн ашиглалтад хүлээлгэн өгөөгүй учир ашиглагдаагүй байна.
- Сүхбаатар суманд шинээр зам тавих ажлын нэг хэсэг болох шарын 13 дугаар байрнаас төмөр зам хүртэлх автозамын ажлын газрын асуудлыг шийдвэрлээгүй учраас ашиглалтад оруулах боломжгүй болсон байна.

Дараах 3 зөвлөмжийг огт хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хууль, тогтоомжийн хүрээнд төлөвлөж, батлах. / Аймгийн ИТХ-д /
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль эрхийн актад нийцүүлэн төлөвлөж, аймгийн ИТХ-д өргөн мэдүүлэн, хэрэгжүүлэх. / Аймгийн Засаг даргад /
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албаар хяналт шалгалт хийлгэж, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр дүнг үнэлэх / Аймгийн Засаг даргад /

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар нийт **1,402.4 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 0.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон, 1,402.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэв. /Хавсралт 6-д дэлгэрэнгүйгээр харуулав/**
Үүнд:

1. Төлбөрийн акт :

- Ерөө сум 15.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Бугант тосгонд гүний худаг гаргах” ажлын захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй атал **0.3 сая** төгрөгийн хяналтын зардлыг сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсныг нөхөн төлүүлэх.

2. Албан шаардлага: Дараах нийт **1,402.1 сая** сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

- Зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй **687.5** сая төгрөгийн өртөг бүхий 11 төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн / аймаг 605.8 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, сумд 81.7 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ /,
- Зураг, төсөв тооцоо судалгааг огт хийгээгүй **192.0** сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн / аймаг 164.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ, сумд 28.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ /,
- Урсгал засвар, эд хогшил, бараа материал худалдан авах зэрэг урсгал зардлын **87.3** сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн / аймаг 15.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, сумд 72.3 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ /,
- Улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардлын 7 төсөл арга хэмжээний **192.3** сая төгрөгийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн / аймаг 3 төсөл, арга хэмжээнд 155.8 сая төгрөг, сумд 4 төсөл арга хэмжээнд 36.5 сая төгрөг /,
- Нээлттэй болон харьцуулалтын аргаар тендер шалгаруулахаас зайлсхийх зорилгоор аймгийн хөрөнгө оруулалтын **70.0** сая төгрөгийн өртөг бүхий 1 төрлийн төсөл, арга хэмжээг 4 төсөл, арга хэмжээ болгон хувааж ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлсэн,
- Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн **110.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах” ажлын техникийн тодорхойлолтыг хууль, журамд нийцүүлэн боловсруулаагүй,
- Мандал сум нь 198.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын гадна фасад, дээвэр засварын ажил”-ын гэрээнд төсөвт өртгийн 5 хувь буюу **9.9** сая төгрөгийн чанарын баталгааг тусгаагүй,
- Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн **49.0** сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар сумын дотор зам засвар”-ын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй,
- Ерөө сум нь “Бугант тосгоны гудамжны гэрэлтүүлэг”-ийн ажилд тендерийн хэмнэлтээс **2.9** сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан, 67.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний хяналтын төсөвт тусгагдсан **1.2** сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг захиалагч, гүйцэтгэгчийн хамтарсан актгүй, гэрээнд тусгалгүйгээр гүйцэтгэгчид олгосон.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймаг, сумд нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого боловсруулаагүй, төсөл, арга хэмжээг үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлж төлөвлөөгүй байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад зураг, төсөв нь хийгдээгүй болон урсгал зардлын шинж чанартай төсөл арга хэмжээг баталж, хэрэгжүүлж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө

- Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг холбогдох стандарт, норм, дүрэм, журмын дагуу боловсруулаагүй байна.
- Төлөвлөсөн төсөл арга хэмжээний 93.6 хувийг бүрэн хэрэгжүүлсэн байна.
- Тус бүр 1 төсөл арга хэмжээнд захиалагчийн болон зураг төсөл зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.
- Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөөгүй, бодит үр нөлөөг тооцоогүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Ш.Оргил-д:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албаар хяналт шалгалт хийлгэж, дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, үр дүнг үнэлж байх.
- Аймгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн эх үүсвэрээр 2017-2018 онд аймгийн нэгдсэн эмнэлэг болон Мандал сумын сум дундын эмнэлэгт бэлтгэн нийлүүлэгдсэн 2 ширхэг томографын аппаратын бүрэн бүтэн байдлыг хангаж, ашиглалтад оруулах.

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

- Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, урт болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдөх,
- Төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлсний үндсэн дээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр шат, шатны ИТХ-д өргөн мэдүүлэх.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ө.Сувдаа-д:

- Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтыг холбогдох хууль, дүрэм, стандартад нийцүүлэн иж бүрэн боловсруулж байх,
- Бүх төсөл, арга хэмжээнд зураг төсөл, зохиогчийн хяналтын гэрээ байгуулж, хэрэгжүүлэх.

Аймгийн ОНӨГ-ын дарга П.Эрдэнэсайхан-д:

- Аймаг, сумдын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг журамд заасны дагуу хүлээн авч, хянаж нэгтгэх.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХОХБТХ-ЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-3834


2020.06.18 № 06/642
танай 2020.06.18 -ны № 96 -т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Ч.ЭНХТУЯА ТАНАА

“Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн тайлбарыг хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА  Ө.СУВДАА



C:\user\albanbichig2020\jijig teotA5

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 2019 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ” СЭДЭВТ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛБАР

	№	Албан шаардлага	Тайлбар
Тайлбар үзнэ үү	1	Хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинж чанартай эд хогшил, бараа, материал худалдан авах, урсгал засварын зардал зэрэг 15.0 сая төгрөгийн өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээг аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.	Цаашид хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахдаа хөрөнгө оруулалтын бус урсгал зардлын шинж, чанартай эд хогшил, барааг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхгүй байх тал дээр анхаарч ажиллана.
Тайлбар үзнэ үү	2	Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 110.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайхан суманд төрийн албан хаагчийн орон сууц худалдан авах” ажлын техникийн тодорхойлолтыг хууль, журамд нийцүүлэн боловсруулаагүй.	Ажлын даалгавар техникийн тодорхойлолтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн боловсруулан ажиллана.
Тайлбар үзнэ үү	3	Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 49.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сүхбаатар сумын дотор зам засвар”-ын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлээгүй.	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл, арга хэмжээнүүдэд зохиогчийн хяналтын гэрээг байгуулан зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэн ажиллана.
Тайлбар үзнэ үү	4	Аймгийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 53.0 сая төгрөг, 2018 онд 200.0 сая төгрөг нийт 253.0 сая төгрөгийн санхүүжилтээр шаардлага, стандарт хангахгүй, хоцрогдсон технологитой 2 ширхэг томографын аппаратыг аймгийн болон Мандал сумын нэгдсэн эмнэлэгт нийлүүлсэн.	Аймгийн хөрөнгө оруулалтаар 2017 онд 53.0 сая төгрөг, 2018 онд 200.0 сая төгрөг нийт 253.0 сая төгрөг санхүүжилтээр шаардлага, стандарт хангахгүй, хоцрогдсон технологитой 2 ширхэг томографын аппаратыг нийлүүлсэн аж ахуйн нэгжийг хуулийн байгууллагад шилжүүлсэн болно.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ӨГСӨН ТАЙЛБАР

Тайлбар 1-4:

Аудитаар илэрсэн зөрчлүүдийг хүлээн зөвшөөрсөн тул тайланд засвар оруулах шаардлагагүй гэж үзлээ.